



## **А хувилбар**

1. Монголын нууц товчоо зохиолын

Хацрыг нь жадалж байвч

Харсан нүдээ цавчдаггүй

Хар цусаа урсгаж байвч

Харьж огт буцдаггүй

Хатуужил ихт Монголтой

Хамаагүй байлдаж болохгүй... гэсэн дүрслэлийн утга санааг зохиолын үйл явдлаар баталж бичээрэй. / 5 оноо/

2. Хувь хүний тэсвэр тэвчээр амьдралын мөн чанарыг уран зохиолд хэрхэн дүрсэлснийг “Монголын нууц товчоо” зохиолын Тэмүжингийн дүр дээр тайлбарлан бичээрэй. 50-60 үгтэй. /5 оноо/

3. Өгүүлбэрт бүрэн задлал хий.

Онгон элсэнд миний өнгөрүүлсэн тэр зун, гэнэн балчир сэтгэлд минь гэрэл гялбаат бодол ухаарал нисэн ирсэн алтан мөчүүдийг эрих шиг хэлхсэн байжээ. /3 оноо/

4. Оньсого бүрийн хариуг таагаад дүрслэх ур маягийг тайлбарлан бичээрэй. /3 оноо/

Сүүлгүй оодон

Сүүжгүй хэлтэн.

Хөлгүй тийрэн

Хөлсгүй гилтэн /..... /

## **Б хувилбар**

1. Д. Равжаа “Үлэмжийн чанар” шүлгийн дүрслэлийн онцлогийг жишээгээр тайлбарлаж, хүмүүний үзэсгэлэнт чанарыг үнэлэх тухай дүгнэн бичээрэй. / 40-60 орчим //5 оноо/

2. “Уншихын залхуурал-ухааны залхуурал”, “Ажилсаг хүн арга хайж байна”, “Туул туньж байна” зэрэг сэдвүүдээс сонгон авч эргэцүүлэмж зохион найруулж бич. /5 оноо/

3. Дараах өгүүлбэрийг салаалан хувирган бич.

Энгэр газар нарны алтан учгаар цэцэг хатгаад, ээлжлэн хувьсах цагийн жам нэхэн он цаг яарсаар нисэж одном. /3 оноо/

4. Оньсого бүрийн хариуг таагаад дүрслэх ур маягийг тайлбарлан бичээрэй.

Лууны нулимсыг тогтоож болохгүй

Лусын шээсийг хэмжиж болохгүй. /3 оноо/

**Авианы найруулгын онцлогийг доорх эхүүдээс олоорой. Юугаар илэрснийг бичээрэй.**

№1 □□□□□□ □□□□ “ ” □□□□□ ”

□“ □□□□□□□ ” □□□□□□□

...” □□□□-□□□ □□□□□□□□□□

Н□□□□□□□-□□□ □□□□□□□□

□□□□□□-□□□□ ” □□ □□□□□□



Н УО- " УО- " 0000  
00' 000У0000-000 00000

№7.0A000 У000A0000- 00-000A 000 00 00  
0A0000 У000 00000000 0000 У0A0 00-000 000 00 xø  
00 0000000 0' 0000 000 00 00  
0000 У00000000- 00-000A 000000 00  
00У 00 У000 00000000 0000 У0A0 00-000 000 00 00  
00 0000000 0' 0000 000 00 00

## АЖЛЫН ХУУДАС №1

1. Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэлээрэй.

Эзэн гэж эзэнд адил  
Эзэн олдох буюу?  
Эх гэж эрмэг цагаагч ижийд адил  
Эх олдох буюу?  
Ер эр хүн баярлаж

### Магнай үл хагарах гэлээ.

Агт морь таргалж  
Арьс үл хагарах гэлээ.  
Авай бор тоором минь  
Юу гэнэм чи  
-Аа авгай минь!

### Сайн хүнд нөхөр олон бишүү.

Сайн моринд эзэн олон бишүү.  
Өнөр хүнд нөхөр олон бишүү.  
Өнчин хүнд ноён олон бишүү.  
Санаат хүнд сэжиг олон бишүү.  
Сайн моринд газар ойр бишүү.

Авгай минь явъя.  
-Авай бор тоором минь!  
Эетэй хүнд нөхөр олон гэлээ.  
Эйлсэн моринд уурга олон гэлээ.  
Эегүй хүнд өстөн олон гэлээ.  
Эцсэн моринд ташуур олон гэлээ

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

## **АЖЛЫНХУУДАС №2.**

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл

.Ижийгээс минь асгарсан улаан бороо

Эцгийн минь зүрхийг норгож арилсны дараа

**Голоон эгштэл хүлээсэн**

**Говь дээгүүр татсан**

**Нарыг зургаа хэрчсэн тоонотой гэр дээгүүр татсан**

**Намайг тэврэх гэж яарсан бүхний өвөр дээгүүр татсан**

**Солонго билээ би**

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

**АЖЛЫН ХУУДАС №3.**

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

**Оосоргүй** цагаан гэр болох болох минь ч яалаа даа

**Онгон** зүрхний амрагаа би ган тулга болгоод

**Оломгүй** дурлалын гал ноцоож дөлөнд нь дулаацахсан

**Оосоргүй** цагаан гэр болох болох минь ч яалаа даа

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

#### **АЖЛЫН ХУУДАС №4**

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

Ц.Дамдинсүрэн : Хоёр цагаан юм

Зуны халуунд Говь-Алтайн сүрлэг хяраар цагаан цас бууралтаж байна. Ар талаар нь ургасан **бага сага** тахир яргайнаас өөр ой мод, өвс ургамал бараггүй баргар их хадан оргил тэнгэрийг хатган үргэлжлээд, завсраар нь хадан хавцал бүрэлзэж байна. **Сэрвийсэн сэхийсэн** өндөр оргилуудыг ажиглахад **үр ач нартаауурлаж загнах занчихыг** завдаж байгаа зэвхий царайтай буурал өвгөн шиг харагдах тул аргагүй сүрдэж ямар ч хүний **зүрх шимширч сэтгэл ширвээдэж, царай барайх** юм.

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

### **АЖЛЫН ХУУДАС №5**

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

**Жаргалан ,жаргалан, жаргалан  
Энэ ертөнцийн түмэн жаргалан  
Түүний доторх чухам жаргалан  
Эрүүл энхийн нэгэн жаргалан.  
Тэмүжин – нумын хөвчнөөс  
төрөөгүй юм  
Тэмүжин - сумын зэвнээс  
гараагүй юм  
Тэмүжин- Өүлэн эхээс төрсөн юм.  
Тэмүжин –өрлөг түүхээс гарсан  
юм  
Чингис- – нумын хөвчнөөс  
төрөөгүй юм**

**Чингис- сумын зэвнээс гараагүй  
юм  
Чингис - Өүлэн эхээс төрсөн юм  
Чингис - өрлөг түүхээс гарсан юм.  
Ядмаг эмгэн  
Чадмаг шөвөгтэй. Шумуул.  
Хөлгүй гулдан баатар  
Хөлсгүй чилдэн баатар  
Сүүжгүй хэлтэн баатар  
.Сүүлгүй оодон баатар  
./ могой,гүрвэл,загас, мэлхий./**

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..



## АЖЛЫН ХУУДАС №7

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

Арван долоон нас ч дээ. Хөөрхий. зайлуул. Би тэгэхэд өөрийгөө эр хүнд тооцож явжээ. Гэтэл тэр зун ёстой шалчгар эр болохоо мэдсэн юм. Долдугаар сарын нэгэн өдөр би нутгийнхаа Чингис хаан болоод түүний залуу гэргийн хамт сумынхаа наадамд очихоор эртлэн мордлоо. **Тэр Чингис хаан гэдэг маань ердөө л шар Цамба юм шүү дээ. Би түүнд ийм догшин сүртэй хоч өгсөн боловч хүнд хэлдэггүй байлаа.**

Хурдан морь уяхад нь би түүнд туслалцсан юм. Тэгэхэд над шиг жулдрай амьтан салхин зээрд, цахилгаан хээр гэх мэт үлгэр домгийн нэртэй тэр сүрхий хөлөг морьдыг нь үдшийн чийг буусан хойно хээр аваачиж идээшлүүлэх, өглөө үүрээр чилээгий нь гаргах, өдөр услах зэрэг хар бор ажил хийхээс өөр ямар тус хүргэх билээ.

Шар Цамба гэгч гуч эргэм настай, ирвэснийх шиг жоотгор шар нүдтэй, буржгар хүрэн үстэй, дундуураа ховилтсон урт эрүүтэй бөгөөд майгавтар богинохон хөлөө бат гишгэж нударгаа үргэлж зангидаж явдаг хүн. Шар нүд нь урин зөөлөн харцтай байхыг би ер үзсэнгүй.

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

## АЖЛЫН ХУУДАС №8.

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

Тэр түмэн зөв. Үүнийг хийхэд цагийг хүлээх хэрэггүй. Танхим гэдэгч нь сүүлдээ шашны **толгой дээр цахиур хагалах** газар./ Ч.Л./

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

**АЖЛЫН ХУУДАС №9.**

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

Байна уу? **Даарийка** юу.нөгөө хоёр **хулгайчаа** бушуул гэж хэлээчээ.Юугаа хийгээд **заваараад** байгаа юм бэ?

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

**АЖЛЫН ХУУДАС №10.**

Эхийг уншаад тодруулсан хэсгийг сайтар ажиглаад уран зохиолын эхэд ямар үгсийг ашигласан байгааг хэл.

**Эрхий ороох сур шиг хүний богинохон заяанд  
Элбэг дутуу нь ялгаагүй амьдын эрээн зүүдэнд  
Нэгэн үзүүр нь тэнгэрээс хөллөж  
Нөгөө үзүүр нь газарт уллах  
Зуурхан төдий татаад арилах  
Зургийн алаг солонго билээ би**

Уран зохиолын найруулгад ямар үгсийг хэрхэн хэрэглэсэн бэ?	Зохиосон жишээ:
1.	1
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.
11.	11..

## Дараах эхийг зөв дараалалд оруулна уу?

Эх нь

### Сайн морь буга болно.

- а. Нэлээд хэсэг явсны дараа хазаарын цулбуураас чангаахад үүргэлж явсан данжаад сэрээд эргэж харвал ,хөтөлж явсан морины оронд нүцгэн хүн явж байсанд учиргүй айн, ум хумгүй зугтжээ.
- б. Урьд нэг данжаад хүний сайн морийг булааж аваад явж байжээ.
- в. Тэгээд эргэж харахад нь нөгөө хүн морь мэт ялаархан толгой хаяж зогссоныг ихэд гайхан “Хааяа сайн морь уг болно оо”гэсэн гэдэг.
- г. Тэр хүн данжаадын хөтөлж яваа морины хазаарыг сэм мулталж суллаад хазаарыг толгойдоо углачихаж гэнэ.
- д. Тэгтэл нутгийн нэг сайн эр уул морийг буцаан авчрахаар шийдэж гэнэ.

## Шууд ба шилжсэн утгат үг, түүний төрөл зүйл

### Ажилах ТӨМ

#### ТӨМ.№ 1.

1.Дараах эхийн санааг хэлцээр илэрхийл.

Хоёрын тоо

Гуравдугаар цагийн завсарлагаанаар

Багш намайг дуудлаа

Гуниг баярын аль нэг нь

Багшаар намайг дуудууллаа.

Эдэлгээ муутайхан дэвтрийг минь дэлгэж

Энэ бодлогыг чи хүнээс будаалжээ...

Ядахдаа зөв хуулсан сан бол

Ялихгүй гярхайг чинь үнэлж “дунд “тавих сан.

Хүний халуун хөлсөөр

Өөрийнхөө дутуугнөхөж явах вийгэхдээ

Хоёр хасах тавилаа гэлээ....

#### ТӨМ.№ 2.

2.Цэгийн оронд зохих хэлцийг сонгон өгүүлбэрийг дэлгэрүүлэн уншаарай.

... Өлзийн гадна очоод нөгөө гал шиг зориг нь эгшин зуур арчсан юм шиг алга болж,гэрт нь оролгүй буцаж явтал зээргэнэ түүгээд ирж явсан Өлзийтэй дайралдав.

- а) Үхсэн буурын толгойноос амьд ат айна гэгчээр
- б) Баатар хүн нэг суманд баян хүн нэг шуурганд гэгчээр
- с) Эр хүнд итгэхээр эрхий хуруундаа итгэ гэгчээр
- д) Тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй гэгчээр

Эш, гэвш минь ..... хаагуур л яваад байна даа.

- а. Ямааны мах халуун дээрээ гэгчээр
- б. Айсан нохой арав хоног хуцна гэгчээр.
- в. Их санасан газар есөн шөнө хоосон гэгчээр.
- г. Гэрээ мартсан Гэсэр гэгчээр.

**ТӨМ.№ 3**

3. Онъсогыг тайлаарай.

- Далдалж нуусан зүйлийг ил хэлсэн зүйлийн тусламжтайгаар бодож олно.
- Далдлагдсан зүйлүүдийн шинж тэмдгийг ялгана.
- Шинж тэмдгүүдийн хооронд байж болох боломжтой холбоог илрүүлэхийн тулд шинж тэмдгүүдийг зэрэгцүүлэн нэгтгэ.
- Тохирох шинж, илрүүлсэн холбоон дээрээ тулгуурланоюун дүгнэлт хийж тайлаарай

Жишээ нь:

Хар хурга

Ясан бөөртэй./ /

Хар хурга байж болох ч  
Ясан бөөр байж болохгүй

Хурга бөөр хоёроор юмыг нууцалсан

Өнгө заасан хар  
Шинж заасан ясан

Үгүйсгэсэн зүйл байхгүй учир ил хэлсэн шинж гэдэг нь мэдэгдэж байна.

Эдгээр шинж тэмдгүүдийг зэрэгцүүлэн нэгтгэж үзвэл “хар хурга” гэдэг нь жижигхэн хэмжээтэй зүйл байх нь. Ясан бөөр гэсэн нь ястай юм нь хар өнгөтэй юмныхаа дотор байх нь гэж дүгнэж болно. Ийм зүйл юу байдаг билээ гэхээр ясан үртэй, хар өнгөтэй хар чавга, мойл, хад жимс байж болно гэх мэтээр тайлна.

Онъсого нь:

Тэнгэрийн нар жаргав

Түмэн хялгас нийлэв

Огторгуйн нар оров

Олон хялгас нийлэв.

**ТӨМ.№ 4.**

1. Нарны тухай онъсого зохио.

2. Нарыг юутай адилтгаж болох .

Шинж	Орон	Цаг	Үйл	Тоо	Шинж	Хэлбэр	Өнгөөр	Үйлээр	хэмжээгээр
------	------	-----	-----	-----	------	--------	--------	--------	------------

Дугари г гэрэлт эй шар халуун	Тэнгэр т огторг уйд Дээр агаарт үүлни й цаана уулын цаана	Өглөө өдөр үдэд мөнхөд насад үүрд ашид байнга үргэлж	Мандах ургах гэрэлтэ х Цацрах дэгжих Голлох Хэвийх таших Хүүшлэ х Жаргах Буцах Хошлох Орох Хиртэх Хүрээл э гэх мэт	Ган ц	Гал цог дөл	Бөмбөг өндөг Шаар Үрэл Шар тос	Шар тос Алт гууль	Өнхрөх эргэлдэх Тойрох халаах	Аягын чинээ
--	---	--	--	----------	-------------------	--	----------------------------	--	----------------

**ТӨМ.№ 5.**

5. гурван мөрөөр зэргэд үүсгэн шүлэглэ.

Өвс ургамал      мод      амьтан      чулуу      эрхтэн

Замаг              зээргэнэ      мэлхий      номин      цөс

Хөгц                хуш      царцаа              нүд

Навч                гацуур      тогос

Хаг

Арц

Өвс ногоо

## Хэлц өгүүлбэр

## АЖЛЫН ХУУДАС

Дараах хэлцийг уншаад:

Яагаад А,Б гэж хоёр хэсэгт ангилсан юм бол утгаар нь юу юу гэж ангилж болмоор байна таамаглал дэвшүүл.

А

- Хөвөн гэхэд ноолуургүй

Хөнжил гэхэд захгүй

Гурил гэхэд устай

Ус гэхэд мөхлөгтэй

- Овоо босгоогүй бол
- Шаазгай хаанаас суух вэ?
- Муу бух толгойдоо шороотой
- Улаан хөлтнийг урдуураа гаргаж үзээгүй
- Айлд очихдоо намар гэрт нь очиход хавар
- Өнгө хөөсөн хүн саламхай  
Өвс хөөсөн мал эцэнхий
- Авах хүнд нэг үг ч эрдэнэ  
Орхих хүнд мянган сургаал ч улиг.

Б .Чихэр идвэл ой гутна

Чимэг ихэдвэл дур гутна.

- Идэх нь идэр  
Явах нь ядар
- Өдрийн бодол шөнийн зүүд
- Авснаа мартах нь адгийн шинж  
эргүүлж өгөх нь эрхэм шинж
- Зунд битгий суу  
Зуданд битгий сандар
- Жаргалтай боловч орондоо бигий дуул  
Зовлонтой боловч орондоо битгий уйл.

## Хэлцийн найруулга

-Баярлах –хөл нь газар хүрэхгүй байх

Аригч –суусан газраасаа шороо атгах

-Хүүе хаая гэхийн хооронд,нүд ирмэхийн зуур,яах ийхийн зуур, хуйхуйд хөөгдсөн юм шиг,ухаан жолоогүй, ум хумгүй,таван яарал ирсэн юм шиг

-Сохор харын өртөөнд явах –

-Давсанд явах

-Араар нь тавих

-Могдорын шөл уулгах/ аль нь дооглосон,егөөдсөн,бичгийн хэлний,хар ярианых вэ?/

### Хэлцийг дүрслэг ба дүрслэг бус гэж ангилна.

А.

Дүрслэг хэлц

Онъсого,далд утгат өгүүлбэр/ ёгтлол/, зүйр үг, дүрслэг үг

Б

Дүрслэг бус хэлц

Цэцэн үг, мэргэн үг,оновчтой үг,сургаал үг

### Өгүүлбэрийг зөв болгоод хэлцийн бүтцийн ангилалын тухай дүгнэлт бич

**Жинхэнэ нэр үйл үгээс бүтсэн хэлц** хөх инээд, улаан нүүрээрээ, хар дотортой

:хүн ахтай, дээл захтай,аяганы алчуур.

**Тэмдэг нэр жинхэнэ нэр бүтсэн хэлц:** яс амрах,ганзага нийлэх,хөл алдах

**Тэмдэг нэр үйл үгээс бүтсэн долоон голтой, далан нөхөөс**

**Жинхэнэ нэр,орон цагийн нэрээс бүтсэн хэлц:**гэм нь урдаа, гэмшил нь хойноо,хайр нь дотроо, хал нь гадгаа.

**Жинхэнэ нэр, жинхэнэ нэрээс бүтсэн хэлц хэлц:**хар дарах,муу нуухаар сайн илчил.

**Үйл үг үйл үгээс бүтсэн хэлц:** яарвал даарна, барж идэхээр мэрг ид.

**Үйл үг орон цагийн нэрээс бүтсэн хэлц:** идэх нь өмнөө, хийх нь хойноо



## Хэлц өгүүлбэр сэдвийн шалгалт

□□□ □□□□□□□□ 1

- a. Ганзага нийлэх, ташуур өгөх, булуу халах, үг алдах мэтийн жинхэнэ нэр үйл үгээс бүтсэн өвөрмөц хэлцийн жишээ 6-ыг бич. / 3 оноо/
- b. хол хэвтэнэ, гонжийнжоо мэтийн бүтцийн хувьд өгүүлбэрт тэнцэх өвөрмөц хэлц 2-ыг бич. / 2 оноо. нийт 5 оноо/

□□□ □□□□□□□□ 2

1. Үс . таван хялгас, үс цайх, үстэй толгой арзайх, үсээ хагалах, үс нь босох, толгой дахь үснээс их мэтээр хүн малын эд эс эрхтэнтэй холбоотой өвөрмөц хэлц 5-ыг үүсгэ. / 2 оноо/

□□□ □□□□□□□□ 3

1. Дараах өвөрмөц хэлцийг үүдэл санаа, гол санаа, дүрслэх ур маягаар нь тайлбарла .  
Яс хаях, хорголоо тоолох, шар сэмжлэх, бүдүүн хүзүү гаргах, нохой хэрэг, /5 оноо/

□□□ □□□□□□□□ 4

Эсрэг утгатай өвөрмөц хэлцийг цэгийн оронд жагсаан бич.

А. өр нимгэн.....

Б. зөөлөн чихтэй.....

В. нүд ирмэх зуур.....

Г. зүү орох зайгүй.....

Д. толгой цохих..... / 5 оноо/

□□□ □□□□□□□□ 5

Тайлбарламж бич. /5 оноо

. Хэнд эрдэм буй бол түүнд тус буй

Хэнд эе буй бол түүнд нөхөр буй

Хэнд эд буй бол түүнд харам буй/



## Холимог нийлмэл өгүүлбэр сэдвийн шалгалт

### Үйл ажиллагаа 1

Дараах эхээс ХоНӨ-ийг олж тайлбарла

.Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа, элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс утаа суунаглана.

Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна. Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодогнон давхина.

Хөлд орохоос аваад, үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ.

Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном гэж буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж хууль ёс гэж худал үнэн ярихыг сонссоор өдөр сарыг улируулна.

Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй гэж бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй гэж сэтгэсээр, түмэн хэргээс хоцорч, дэлхийн боловсролоос гээгдэнэ.

### Үйл ажиллагаа 2.

Дараах өгүүлбэрүүдийг гүйцээж бич./ ХоНӨ болгоно

Хүн байгалийн эрдэст Хужирт усыг өдөр тутмын ундны хэрэгцээнд тогтмол хэрэглэ...хүний биен дэх тэнцвэр хэвийн хэмжээнд хадгалагд,,,,амин чухал шаардлагатай эрдэсжилтийн дутагдлаас өөрийгөө хамгаалж чадна.

### Үйл ажиллагаа 3

Дараах оньсогыг таагаад утгыг ХоНӨ –ээр илэрхийл.

Харахад хүн шиг

Хангинах нь төмөр шиг

Аа яасан жигтэй юм бэ?

Аль газрын дархан хийсэн юм бол?

### Үйл ажиллагаа 4.

Дараах мэргэн үгийн голсанаагаар 60-80 үгтэй эх зохио.

Муу, тэр тусмаа өөрт хор уршигтай зүйлийг хийх амархан. Сайн, ашигтайзүйлийг хийх харин даанч хэцүү.

### Үйл ажиллагаа 5

Таны зохиосон эхэд 3 ХоНӨ байх ёстой

.Тэр өгүүлбэрээ зурж тайлбарла.